**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баруунтуруун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/61/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Т.Намжил<br>Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023. 02. 15 № УВА-2023/61/МА-СТА-ТУ1
танай____________-ны №____________-т

БАРУУНТУРУУН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.БАТТУЛГА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруунтуруун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунтуруун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200541

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
Дүгнэлтийн үндэслэл ..... 3
Асуудлыг онцолсон хэсэг ..... 3
Аудитын гол асуудал ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 3
4.1 Ерөнхий зүйл ..... 11
4.2 Материаллаг байдал ..... 12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 12
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 350,000.00 | 350,000.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 350,000.00 | 350,000.00 |
| 35400 | Хангамжийн материал | 350,000.00 | 350,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 350,000.00 | 350,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 8,299,617.42 | 3,134,617.56 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,299,617.42 | 3,134,617.56 |
| 39100 | Газар | 0.00 | 0.00 |
| 39200 | Биет хөрөнгө | 8,299,617.42 | 3,134,617.56 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 0.00 | 0.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 0.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 11,403,300.00 | 11,403,300.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -7,285,441.59 | -11,086,541.55 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 11,502,000.00 | 12,332,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -10,018,666.61 | -11,204,666.59 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,174,150.00 | 12,174,150.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,475,724.38 | -10,483,624.30 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 488,000.00 | 488,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -488,000.00 | -488,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 8,649,617.42 | 3,484,617.56 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 60,066.00 | 0.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 60,066.00 | 0.00 |
| 41100 | Богино хугацаат үнэт цаас | 0.00 | 0.00 |
| 41300 | Өглөг | 60,066.00 | 0.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 60,066.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,589,551.42 | 3,484,617.56 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 8,589,551.42 | 3,484,617.56 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 2,424,000.00 | 2,424,000.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 2,424,000.00 | 2,424,000.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 5,987,646.42 | 882,712.56 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 10,731,038.90 | 5,987,646.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -4,743,392.48 | -5,104,933.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 177,905.00 | 177,905.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 8,649,617.42 | 3,484,617.56 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 67,754,300.00 | 64,811,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 67,754,300.00 | 64,811,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 815,000.00 | 0.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 66,939,300.00 | 64,811,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 66,939,300.00 | 64,811,800.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 72,497,692.48 | 69,916,733.86 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 72,497,692.48 | 69,916,733.86 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 62,374,099.47 | 69,582,872.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 42,513,537.27 | 45,275,130.50 |
| 210101 | Үндсэн цалин | 32,638,074.87 | 29,220,858.59 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 5,744,576.01 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 9,875,462.40 | 10,309,695.90 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,550,675.72 | 5,589,748.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,996,920.86 | 3,801,028.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 389,254.70 | 447,179.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 311,403.73 | 357,743.86 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 74,586.88 | 89,435.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 778,509.55 | 894,359.78 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,335,260.00 | 2,314,394.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 524,000.00 | 249,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,087,860.00 | 1,197,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 597,300.00 | 837,394.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 126,100.00 | 30,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 77,760.00 | 0.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 77,760.00 | 0.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 483,000.00 | 360,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 483,000.00 | 360,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 343,300.00 | 216,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,000.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 216,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 65,300.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,070,566.48 | 15,827,399.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 528,500.00 | 8,999,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,148,000.00 | 833,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,394,066.48 | 5,994,999.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,123,593.01 | 333,861.03 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,479,800.00 | 166,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,200.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 166,600.00 | 166,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,643,793.01 | 167,261.03 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,643,793.01 | 167,261.03 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -4,743,392.48 | -5,104,933.86 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 67,754,300.00 | 64,811,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 67,754,300.00 | 64,811,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 815,000.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 815,000.00 | 0.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 66,939,300.00 | 64,811,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 66,939,300.00 | 64,811,800.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 66,971,300.00 | 63,981,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 66,971,300.00 | 63,981,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 56,847,706.99 | 63,647,938.97 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 42,513,537.27 | 45,335,196.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 32,638,074.87 | 29,537,584.88 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 5,487,915.72 |
| 210104 | Урамшуулал | 9,875,462.40 | 10,309,695.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,490,609.72 | 5,589,748.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,793,332.39 | 3,801,028.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 425,135.31 | 447,179.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 340,108.22 | 357,743.86 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 81,762.99 | 89,435.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 850,270.81 | 894,359.78 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,376,000.00 | 2,365,994.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 500,000.00 | 249,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,197,100.00 | 1,197,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 597,300.00 | 837,394.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 81,600.00 | 81,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 50,000.00 | 0.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,000.00 | 0.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 483,000.00 | 360,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 483,000.00 | 360,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 473,800.00 | 348,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 192,500.00 | 258,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 90,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 65,300.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,460,760.00 | 9,647,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,312,760.00 | 8,814,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,148,000.00 | 833,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,123,593.01 | 333,861.03 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,479,800.00 | 166,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,200.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 166,600.00 | 166,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,643,793.01 | 167,261.03 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,643,793.01 | 167,261.03 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 783,000.00 | 830,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 783,000.00 | 830,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 783,000.00 | 830,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 783,000.00 | 830,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 783,000.00 | 830,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -783,000.00 | -830,000.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 2,424,000.00 | 177,905.00 | 10,731,038.90 | 13,332,943.90 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,424,000.00 | 177,905.00 | 10,731,038.90 | 13,332,943.90 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -4,743,392.48 | -4,743,392.48 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,424,000.00 | 177,905.00 | 5,987,646.42 | 8,589,551.42 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,424,000.00 | 177,905.00 | 5,987,646.42 | 8,589,551.42 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,424,000.00 | 177,905.00 | 5,987,646.42 | 8,589,551.42 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -5,104,933.86 | -5,104,933.86 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,424,000.00 | 177,905.00 | 882,712.56 | 3,484,617.56 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| ЭЗА | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **64,811,800.00** | **64,644,538.97** | 167,261.03 | 99.742 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **64,811,800.00** | **64,644,538.97** | 167,261.03 | 99.742 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **64,645,200.00** | **64,477,938.97** | 167,261.03 | 99.741 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **45,404,100.00** | **45,335,196.50** | 68,903.50 | 99.848 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 35,361,700.00 | 29,537,584.88 | 5,824,115.12 | 83.530 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 5,487,915.72 | -5,487,915.72 | #DIV/0! |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| 210104 | Урамшуулал | 10,042,400.00 | 10,309,695.90 | -267,295.90 | 102.662 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **5,675,300.00** | **5,589,748.47** | 85,551.53 | 98.493 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,859,300.00 | 3,801,028.97 | 58,271.03 | 98.490 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 454,000.00 | 447,179.90 | 6,820.10 | 98.498 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 363,200.00 | 357,743.86 | 5,456.14 | 98.498 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 90,800.00 | 89,435.96 | 1,364.04 | 98.498 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 908,000.00 | 894,359.78 | 13,640.22 | 98.498 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,375,800.00** | **2,365,994.00** | 9,806.00 | 99.587 |
| 210401 | Бичиг хэрэг | 249,900.00 | 249,900.00 | 0.00 | 100.000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,197,100.00 | 1,197,100.00 | 0.00 | 100.000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 847,200.00 | 837,394.00 | 9,806.00 | 98.843 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 81,600.00 | 81,600.00 | 0.00 | 100.000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **833,000.00** | **830,000.00** | 3,000.00 | 99.640 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 833,000.00 | 830,000.00 | 3,000.00 | 99.640 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **360,200.00** | **360,200.00** | 0.00 | 100.000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 360,200.00 | 360,200.00 | 0.00 | 100.000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **348,900.00** | **348,900.00** | 0.00 | 100.000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 258,900.00 | 258,900.00 | 0.00 | 100.000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 90,000.00 | 0.00 | 100.000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,647,900.00** | **9,647,900.00** | 0.00 | 100.000 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,814,900.00 | 8,814,900.00 | 0.00 | 100.000 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 833,000.00 | 833,000.00 | 0.00 | 100.000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **166,600.00** | **166,600.00** | 0.00 | 100.000 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **166,600.00** | **166,600.00** | 0.00 | 100.000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 166,600.00 | 166,600.00 | 0.00 | 100.000 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **64,811,800.00** | **64,811,800.00** | 0.00 | 100.000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **0.00** | **0.00** | 0.00 | #DIV/0! |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **64,811,800.00** | **64,811,800.00** | 0.00 | 100.000 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 64,811,800.00 | 64,811,800.00 | 0.00 | 100.000 |
| **37** | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | **0.00** | **0.00** | 0.00 | #DIV/0! |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **5.00** | **5.00** | 0.00 | 100.000 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | 0.00 | 100.000 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.000 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **2.00** | **2.00** | 0.00 | 100.000 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.000 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.000 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| 620004 | Гэрээт ажилтан | 0.00 | 0.00 | 0.00 | #DIV/0! |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **2.00** | **2.00** | 0.00 | 100.000 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1.00 | 1.00 | 0.00 | 100.000 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 1.00 | 1.00 | 0.00 | 100.000 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын ИТХ нь нутгийн өөрөө удирдах байгууллага бөгөөд түүнд тайлагнадаг гүйцэтгэх удирдлагаар уламжлан нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг хуулийн хүрээнд зохицуулдаг байгууллага юм.

Ардчиллыг бэхжүүлж, төрийн захиргааны манлайллыг төлөвшүүлэх, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэх, тэдний нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангах зорилготой байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд дотооддоо сумын Засаг дарга, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд ААН-үүд, гадаад талдаа дээд шатны байгууллага,яам агентлаг, Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газраас гарсан шийдвэр, үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх, зохион байгуулах зэргээр ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитыг ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Баруунтуруун сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон гэж үзэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Баруунтуруун сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,165.0 сая төгрөгөөр буюу 62.2 хувиар буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | | | |
| Бараа материал | 350.0 | 350.0 | 0 |
| Үндсэн хөрөнгө | 8,299.6 | 3,134.6 | -5,165.0 |
| **Нийт хөрөнгө** | **8,649.6** | **3,484.6** | -5,165.0 |
| Өр төлбөр | 60.0 | 0 | -60.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 8,589.6 | 3,484.6 | -5,105.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **8,649.6** | **3,484.6** | -5,165.0 |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс, авлагын данс үлдэгдэлгүй, бараа материал дансанд өөрчлөлт ороогүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,134.6 мянган төгрөг болж 5,165.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 830.0 мянган төгрөгөөр тоног, төхөөрөмж худалдан авснаар нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө данс нь элэгдлийн зардал 5,995.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр данс 60.0 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,484.6 мянган төгрөг болж 5,105.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 88,923.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 88,923.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 14,709.1 мянга, хангамж бараа материалын зардлыг 713.1 мянган төгрөгөөр гэх мэт зарим зардлыг танаж, 59,811.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь ковидын дараах улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 59,811.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг урд оны давсан орлогоос бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 59,811.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн давсан орлогоос 5,000.0 мянган төгрөгийг нэмж олгон, нийт 64,811.8 сая төгрөгийн төсөвтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 64,644.5 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна. Үндсэн данснаас 167.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагаа | 49,505.90 | 44,338.60 | 167.20 | 89.50 |
| | Мэдээлэл сурталчилгааны зардал | 193.40 | 193.40 | 0 | 100 |
| | БИНХ даргын урамшуулал | 11,297.60 | 11,297.60 | 0 | 100 |
| | ГХУСЗ | 3,814.90 | 3,814.90 | 0 | 100 |
| | Ангилагдаагүй | | 5,000.00 | -5,000.00 | |
| | Нийт | 64,811.80 | 64,644.50 | | 99.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөв буюу байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баруунтуруун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунтуруун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 2/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 724.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 69,916.7 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 699.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 559.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Баруунтуруун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, мэдээлэл байршуулаагүй 2, хугацаандаа 147 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Баруунтуруун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баруунтуруун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3,390.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,355.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг ирүүлсэн байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Баруунтуруун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 175.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

### 5.1 Төлбөрийн акт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх заалтад "Гар утасны зардал" гэж заасныг зөрчин Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 175.0 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөнд буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 175.0 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөн байна | 1 | 175.0 | 1 | 175.0 | | | | | | | | |
| Дүн | 1 | 175.0 | 1 | 175.0 | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ УДИТОР /Т.НАМЖИЛ/

2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 02 сарын 16 өдөр Дугаар 01/02/А2060412 Улаангом
УВА-2021/61/НА-СТА-ТЧ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баруунтуруун сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 175.0 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх заалтад "Гар утасны зардал" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8 дахь заалтад "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан гар утасны нэгжийн үнэ 175 000 /нэг зуун далан таван мянга/ төгрөгийг төрд хохирол учруулсан буруутай албан тушаалтнаар төлүүлж Орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Баруунтуруун сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Баттулга, нягтлан бодогч С.Элдэвсайхан нарт хариуцуулав.

---

[1] *Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317*

02005000 9

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

| | |
|---|---|
| АХЛАХ АУДИТОР | Т.НАМЖИЛ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | М.БАТ-АМГАЛАН |
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | М.БАТСУУРЬ |

**ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

## А. Төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

| | | | |
|---|---|---|---|
| 1.1 Аудитын нэр | Баруунтуруун сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит | 1.2 Аудитын код | УВА-2023/61/НА-СТА-ТШЗ |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3 Аудит хийсэн үндэслэл | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 | 1.4 Аудитын төрөл | Санхүүгийн тайлангийн аудит |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.5 Төлбөрийн актын дугаар | | 1.6 Огноо | 2023.02.14 | 1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/ | 175,000 |

<table>
<tr><td rowspan="5">1.8 Төлбөрийн акт тогтоох үндэслэл</td><td>Алдаа, зөрчлийн товч утга</td><td colspan="2">Төсвийн хөрөнгөөр ажилтнуудад 175.0 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөн байна.</td></tr>
<tr><td>Алдаа, зөрчлийн ангилал</td><td colspan="2">Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй</td></tr>
<tr><td>Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)</td><td colspan="2">4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн”</td></tr>
<tr><td rowspan="2">Зөрчсөн эрх зүйн актын</td><td>Нэр</td><td>Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, хэмнэлтийн тухай хууль</td></tr>
<tr><td>Заалт</td><td>Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 дэх заалтад “Гар утасны зардал”</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | Үндэслэл болгосон эрх зүйн актын | Нэр | Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8 дахь заалт |
| | | Заалт | Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” |

| | | | |
|---|---|---|---|
| 1.9 Зөрчил барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/ | Улсын төсвийн дансанд | | 1.10 Зөрчил барагдуулах огноо |
| | Орон нутгийн төсвийн дансанд | 175,000 | |
| | Тухайн байгууллагын дансанд | | |
| | Зөрчил арилгах | | 2022.03.30 |
| | | | |

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

| № | Нотлох баримтын нэр төрөл | Дугаар | Огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Төлбөрийн хүсэлт | №54 | 2022.05.09 | Арвин амтлаг ХХК-д |
| 2 | И-баримт | | 2022.05.03 | Арвин амтлаг ХХК-д |
| 3 | Зарлагын баримт | № | 2022.05.03 | Арвин амтлаг ХХК-д |
| 4 | Олгосон жагсаалт | | 2022.05.03 | Ажилтнуудын нэрсийн жагсаалт гарын үсэгтэй |

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

| № | Аудитын багийн | | Хариуцагч | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Албан тушаал | Овог нэр | Байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Холбоо барих хаяг, утас |
| 1 | Ахлах аудитор | Т.Намжил | Баруунтуруун сумын ИТХ | Нарийн бичгийн дарга | Д.Баттулга | 88556818 |
| | | | | Нягтлан бодогч | С.Элдэвсайхан | 88556818 |
| | | | | | | |

Төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

| № | Албан тушаалтан | Огноо | Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Аудитын менежер | 2023.02.15 | — | [signature] |
| 2 | Дарга, тэргүүлэх аудитор | 2023.02.15 | — | [signature] |

4.2 Төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

| № | Албан тушаал | Овог нэр | Огноо | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Дарга, тэргүүлэх аудитор | М.Батсуурь | 2023.02.15 | [signature] |

2. Төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

| № | Үзүүлэлт | | | Мэдээлэл оруулах хэсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн | | Огноо | 2023.02.25 | |
| | | | Дугаар | ................ | |
| 2 | Төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн | Огноо | | 2023.02.25 | |
| | | Ажилтны | Овог нэр | Т.Намжил | |
| | | | Албан тушаал | Ахлах аудитор | |
| 3 | | Байгууллагын нэр | | Баруунтуруун сумын ИТХ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Төлбөрийн актыг хүлээн авсан | Ажилтны | Овог нэр | С.Элдэвсайхан | |
| | | | Албан тушаал | Нягтлан бодогч | |
| 4 | Төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах | Газрын нэр | | Баруунтуруун сумын ИТХ | |
| | | Ажилтны | Овог нэр | Д.Баттулга | |
| | | | Албан тушаал | Нарийн бичгийн дарга | |
| 5 | Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж | Санхүүгийн | Тоо | 1 | |
| | | | Дүн | 175,000 | |
| | | Санхүүгийн бус үр өгөөжийн тоо | | | |

**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**
Байгууллагын нэр: Баруунтуруун сумын ИТХ
Тайлант хугацаа: 2022.01.01-2022.12.31

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа. зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан ~тушаал | *Овог* нэр |
| A | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | 2022 оны Санхүүгийн тайлангийн аудит | Шуудан холбооны зардлаас байгууллагын ажилтнуудад 175.0 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авч өгсөн байна. | 175,000 | Төлбөрийн акт | | | Төлбөрийн акт | Баруунтуруун сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга<br>Нягтлан бодогч | Д.Баттулга<br>С.Элдэвсайхан |

**Бэлтгэсэн:**
Ахлах аудитор
Албан тушаал, овог нэр, гарын үсэг — Т.Намжил, Огноо: 2023.02.13

**Анхан шатанд хянасан:**

Аудитын менежер — М.Бат-Амгалан

Албан тушаал, овог нэр, гарын үсэг — Огноо: 2023.02.13

**Хоёр дахь шатанд хянасан:**
Дарга, тэргүүлэх аудитор — М.Батсуурь
Албан тушаал, овог нэр, гарын үсэг — Огноо: 2023.02.13

**Танилцаж зөвшөөрсөн:**
Нягтлан бодогч
Албан тушаал, овог нэр, гарын үсэг — С.Элдэвсайхан, Огноо: 2023.02.13

**Танилцаж зөвшөөрсөн:**

Баруунтуруун сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга — Д.Баттулга

Албан тушаал, овог нэр, гарын үсэг — Огноо: 2023.02.13